



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Угтахуй ӨЭМТ-ийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/166/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал
Утас: 70007734

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Санхүүгийн аудитын албаны аудитын менежер: Д.Отгонбаяр
Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:
Бэст фортуна аудит ХХК-ийн захирал: Ж.Оюунцэцэг
Утас: 324338, 89116465, 98056465
Цахим хаяг: fortune2009audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.05.13 № 795
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
УГТАХУЙ ӨЭМТ-ИЙН ДАРГА
Ж.САРАНДЭЛГЭР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Угтахуй ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүхий л материаллаг байдлын үүднээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар нийт 58.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, нягтлан бодох бүртгэлийн олон улын стандарт болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас нэг иргэнээр тооцсон зардлын санхүүжилтээр 1,362.9 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний санхүүжилтээр 491.2 сая төгрөгийн, Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газраас эрүүл мэндийн ажилтны өдөрт 8.0 сая төгрөг, дархлаажуулалтын зардалд 1.0 сая төгрөгийн, дархлаажуулалтын зардалд Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвөөс 13.7 сая төгрөгийн, Нийслэлийн эрүүл мэндийн газраас 2.5 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажилласан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Баянгол дүүргийн Угтахуй ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 85.5 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 98.2 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31-ний үлдэгдэл	2025.12.31-ний үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	37,252,151.34	69,724,386.55
1.1.2	Дансны авлага	129,378,798.23	22,356,806.40
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.6	Бараа материал	9,024,222.00	3,323,055.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	175,655,171.57	95,404,247.95
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	321,036,165.75	294,997,395.18
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	321,036,165.75	294,997,395.18
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	496,691,337.32	390,401,643.13
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		759,600.00
2.1.1.2	Цалингийн өглөг		116,332.45
2.1.1.3	Татварын өр		283,114.00
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	1,159,046.45
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	1,159,046.45
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч: а) төрийн	61,630,805.56	61,630,800.00
2.3.2	б) хувийн	710,000.00	710,000.00
2.3.3	в) хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,531,644.05	6,531,600.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	427,818,887.71	320,370,196.68
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	496,691,337.32	389,242,596.68
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	496,691,337.32	390,401,643.13

Нийслэлийн Баянгол дүүргийн Угтахуй ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,935,932,048.73	1,876,439,452.80
2	Борлуулалтын өртөг	1,744,497,184.88	1,948,710,580.38
3	Нийт ашиг (алдагдал)	191,434,863.85	(72,271,127.58)
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	1,485,541.59	1,829,279.48
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	93,860,550.00	33,843,107.46
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал		
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	69,844,500.00	70,850,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	216,936,455.44	(107,448,740.64)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	216,936,455.44	(107,448,740.64)
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	216,936,455.44	(107,448,740.64)

Нийслэлийн Баянгол дүүргийн Угтахуй ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,884,426,588.50	2,008,877,218.63
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
	Татаас санхүүжилтийн орлого	1,879,004,588.50	1,983,461,444.63
	Бусад мөнгөн орлого	5,422,000.00	25,415,774.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,753,562,527.90	1,922,447,262.90
	Ажиллагсад олгосон	1,272,930,573.82	1,105,788,080.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	124,719,058.73	304,281,602.20
	Бараа материал худалдан авахад төлсөн	270,543,395.35	195,869,587.46
	Татварын байгууллагад төлсөн		19,965,669.00
	Бусад мөнгөн зарлага	85,369,500.00	96,542,324.24
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	130,864,060.60	86,429,955.73
2	Хөрөнгө оуулалалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,485,541.59	1,829,279.48
	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
	Хүлээн авсан хүүгийн орлого	1,485,541.59	1,829,279.48
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	95,212,645.00	55,787,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	95,212,645.00	55,787,000.00
	ХО-ын бусад мөнгөн зарлага	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(93,727,103.41)	(53,957,720.52)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Бусад орлого	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Бусад зарлага	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
	Валютын ханшийн зөрүү		
4	БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	37,136,957.19	32,472,235.21
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	115,194.15	37,252,151.34
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37,252,151.34	69,724,386.55

Нийслэлийн Баянгол дүүргийн Угтахуй ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	62,340,805.56	6,531,644.05	210,882,432.27	279,754,881.88
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	(5.56)	(44.05)	49.61	-
3	Залруулсан үлдэгдэл	62,340,800.00	6,531,600.00	210,882,481.88	279,754,881.88
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			216,936,455.44	216,936,455.44
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт				-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэргжсэн дүн				-
8	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	62,340,800.00	6,531,600.00	427,818,937.32	496,691,337.32
9	Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
10	Залруулсан үлдэгдэл	62,340,800.00	6,531,600.00	427,818,937.32	496,691,337.32
11	Бусад дэлгэрэнгүй орлого				-
12	Өмчид гарсан өөрчлөлт				-
13	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэргжсэн дүн				-
14	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(107,448,740.64)	(107,448,740.64)
15	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	62,340,800.00	6,531,600.00	320,370,196.68	389,242,596.68

3 АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 438.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

Аудитаар 58,315.7 мянган төгрөгийн зөрчил илэрч 705.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 57,610.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 58,315.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Дээрх аудитын шийдвэрийн биелэлтийг НТАГ-т 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн, Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүнг зөрүүтэй илэрхийлсэн	1	438.0			1	438.0	1	438.0				
Дүн	1	438.0	0	-	1	438.0	1	438.0	-	-	-	-

Нийслэлийн Баянгол дүүргийн Угтахуй ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Аялалын компанитай гэрээ байгуулж 12 ажилтныг туршлага судлах нэрээр гадаадад аялалд явуулж Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан.	1	51,870.0			1	51,870.0						
ӨЭМТ-ийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн "Гадаад оронд туршлага судлах тухай" №А/18 дугаартай тушаалын дүнгээс илүү шилжүүлсэн.	1	705.7	1	705.7								
Угтахуй ӨЭМТ-ийн даргын 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн "Тэтгэмж олгох тухай" №А/... дугааргүй тушаалын үндэслэл хэсэгт холбогдох хуулийн заалт байхгүй, дотоод журамд тусгаагүй, нийт ажилтнуудад буцалтгүй тусламж нэрээр 57,400.0 мянган төгрөг олгосон, ХХОАТ-ыг холбогдох хуулийн дагуу 5,740.0 мянган төгрөг суутган тооцоогүй	1	5,740.0			1	5,740.0						
Ажилтнуудад хавсран ажилласны нэмэгдэл цалинг олгохдоо тухайн хавсран ажиллаж байгаа албан тушаалын цалингаас тогтоосон хувиар тооцож олгох ёстой байтал тухайн нэмэгдэл цалин авч байгаа ажилтны өөрийнх нь албан тушаалын үндсэн цалингаас тогтоосон хувиар олгосон ба бүтэц орон тоо баталсан тушаал, хавсран ажиллах орон тооны тушаалд үндсэн цалинг тодорхой заагаагүй.	1	-					1					
Дүн	4	58,315.7	1	705.7	2	57,610.0	1	-	-	-	-	-

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 2025 оны 1-р улиралд 2 удаагийн шилжүүлгээр хийгдсэн 49,870.0 мянган төгрөгийн сургалтын төлбөр, 4-р улиралд хийгдсэн 11,855.0 мянган төгрөгийн иммуналогийн аппаратыг мэдээллээгүй	1	61,725.0					1	61,725.0
Дүн	1	61,725.0	0	0	0	0	1	61,725.0